



НИЙСЛЭЛИЙН  
НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/06

Улаанбаатар хот

Нийтийн тээврийн үйлчилгээний  
чиглэлийн замналд зогсоол нэмэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/536 дугаар захирамжаар баталсан “Нийтийн тээврийн бодлогын газрын дүрэм”-ийн 4.1.2.1, 4.1.2.2, 7.1.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж, иргэдийн эрэлт хэрэгцээг хангах үүднээс Хан-Уул дүүргийн 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт байршилтай Ривер гарден (хойд) зогсоолыг шинээр нээж Ч:63 “Хан хиллс хотхон – Ривер гарден – МУБИС – Ард кино театр” чиглэлд нэмж чиглэлийн замналыг нэгдүгээр хавсралтаар, Ч:84 “Бага тэнгэр сити – Хан хиллс хотхон – 120 мянгат” чиглэлд нэмж чиглэлийн замналыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Дээрх чиглэлүүдийн өөрчлөлтийг программ хангамжид оруулж, нэгдсэн даалгаварт тусган үйлчилгээг 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлүүлэхийг Тээврийн бодлого, судалгааны хэлтэс (Д.Баясгалан)-т, тухайн чиглэлийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Зорчигч тээврийн хэлтэс (Х.Баасансүрэн)-т, ажлын гүйцэтгэлийг үндэслэн холбогдох санхүүжилтийг тооцож ажиллахыг Санхүү, аж ахуйн хэлтэс (Б.Бадамдорж)-т, үйлчилгээг батлагдсан замналын дагуу явуулахад хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын хэлтэс (Ц.Мягмар)-т, иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (З.Цэвээндорж)-т тус тус даалгасугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан тус газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/06 дугаар тушаалын хавсралт, 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А/98 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (З.Цэвээндорж)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ

D:\alban khereg\явсан бичиг-2026\TUSHAAI.docx

1726020104

ХТҮ6986 9024050915 2117428




Нийтийн тээврийн газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/03 дугаар тушаалын 01 дүгээр хавсралт

# Ч:63 “ХАН ХИЛЛС ХОТХОН – РИВЕР ГАРДЕН – МУБИС – АРД КИНО ТЕАТР”



Нийтийн Тээврийн  
Бодлогын Газар



А.ХТ6966 9024050915 2117420



## Тайлбар :



Эргэлтийн урт:	<b>12,3 км</b>	Эцсийн зогсоол	Газрын налуугийн градус /уруу/
Эргэлтийн хугацаа:	<b>50 МИН</b>	Хоёр чиглэлдээ зогсдог зогсоол	Газрын налуугийн градус /өгсүүр/
Зогсох буудлын тоо:	<b>15</b>	Нэг чиглэлдээ зогсдог зогсоол	Гэрлэн дохио
Дайран өнгөрөх уулзварын тоо:	<b>17</b>	Гудамжны нэр	Гүүр
			Аюулгүйн тойрог

Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/03 дугаар тушаалын 02 дугаар хавсралт

# Ч:84 Бага тэнгэр Сити - Хан Хиллс хотхон-120 мянгат



Нийтийн Тээврийн  
Бодлогын Газар



## Тайлбар :

Эргэлтийн урт:	12.5 км	Бага тэнгэр сити	Эцсийн зогсоол	Газрын налуугийн градус /уруу/
Эргэлтийн хугацаа:	50 мин	Оршил зогсоол	Хоёр чиглэлдээ зогсдог зогсоол	Газрын налуугийн градус /өгсүүр/
Зогсох буудлын тоо:	12	Скай резиденс	Нэг чиглэлдээ зогсдог зогсоол	Гэрлэн дохио
Дайран өнгөрөх уулзварын тоо:	1	Хөдөлгөөний чиглэл	Гудамжны нэр	Гүүр
		Эхлэх чиглэл		Аюулгүйн тойрог